


“Царцаа шоргоолж хоёр”

Гүрж ардын үлгэр

БАГАЧУУДАА!


**Анхааралтай
сонсоорой.**

Нэгэн удаа царцаа шоргоолж хоёр
хамтдаа зугаалан явж байлаа.




Замд нь нэгэн гол тааралдаж гэнэ.

Би ч яахав
харайгаад гарчихна.
Харин найз минь чи
гарч чадах уу?



Би ч гэсэн
харайгаад
гарчихна аа.




Царцаа харайгаад гарчихлаа.

Харин шоргоолж
усанд уначихав
ГЭНЭ.



Царцаа шоргоолж найзыгаа уснаас
гаргахын тулд гахайгаас хялгас олж
ирэхээр явлаа.



Гахай гуай, гахай гуай
та надад хялгаснаасаа
өгөөч. Хялгасаар чинь
би дээс томоод усанд
унасан шоргоолж
найзыгаа аврах гэсэн
юм.



Надад царс модны
бяцхан үр авчирч
өгвөл би
хялгаснаасаа өгье



Царцаа царс модны үр авчирахаар цааш явлаа.





Царс гуай, царс гуай та
надад үрнээсээ өгөөч.
Үрийг чинь би гахайнд
өгөөд, гахай надад
хялгас өгөөд түүгээр
нь би дээс томоод
усанд унасан
шоргоолж найзыгаа
аврах гэсэн юм.

Надаас хэрээг
зайлуулж өг.
Тэгвэл би
үрнээсээ өгье.



Царцаа царс модонд байнга суудаг
хэрээтэй уулзахаар цааш явлаа.



**Хэрээ гуай, хэрээ
гуай та царс
модноос холдож тус
болооч?**


**Би усанд унасан
шоргоолж найзыгаа
аврах гэсэн юм.**




Чи надад будаа
авчирч өгвөл би
царс модноос
холдъё.



Царцаа байшингаас будаа байнга авчирахаар цааш явлаа.




Намайг байнга
мэрээд байгаа
хулганыг зайлуулж
өгвөл би чамд
будаанаасаа өгье.




Байшин гуай,
байшин гуай та
будаанаасаа
өгөөч. Би усанд
унасан шоргоолж
найзыгаа аврах
гэсэн юм.



Царцаа хулганатай уулзахаар цааш явлаа.



Хулгана гуай,
хулгана гуай та
байшин мэрэхээ
болиоч. Би усанд
унасан шоргоолж
найзыгаа аврах
ГЭСЭН ЮМ.



Чи мууранд очоод
“Хулгана барихаа
боль” гэж хэлвэл
би мэрэхгүй ээ.




Царцаа мууртай уулзахаар цааш явлаа.



Чи надад шинэхэн
сайхан сүү авчирч
өгвөл би
“Хулгана барихаа
больёо оо.



Муур гуай, муур
гуай хулгана
барихаа боливол
би усанд унасан
шоргоолж
найзыгаа аврах
гээд байна.



Царцаа үнээтэй уулзаж сүү авчирахаар цааш явлаа.



Үнээ гуай, үнээ
та надад гуай
сүүнээсээ өгөөч.
Би усанд унасан
шоргоолж
найзыгаа аврах
гэсэн юм.



Чи надад
шинэхэн өвс
авчирч өгвөл
би сүүнээсээ
өгье.




**Царцаа тал газраас шинэхэн
сайхан өвс түүж, үнээнд өгөхөөр
явлаа.**








Царцаа бүх амьтны хүслийг
биелүүллээ.




Тэгээд царцаа хялгасаараа дээс томоод
нэг үзүүрээс нь өөрөө барьж, нөгөө
үзүүрээс шоргоолж барьж найзыгаа
уснаас татаж гаргалаа.




Ингээд тэр хоёр цааш зугаалан явлаа.





Анхаарал тавьсанд
баярлалаа.



Өдрийн 4-1 ангийн
оюутан: Б.Ганчимэг